МЭДЭЭ · 2026 оны 5-р сарын 8

ЗӨРЧИЛ ҮЙЛДСЭН 2,698,478 ХҮНД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛЖЭЭ



Улсын хэмжээнд 2026 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих" зөрчил үйлдсэн нийт 2,698,478 хүнд шийтгэл оногдуулжээ. Үүнээс шүүхээс 6,965 хүнд, эрх бүхий албан тушаалтнаас 2,691,513 хүнд шийтгэл оногдуулсан байна.

Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих" зөрчлөөс тээврийн хэрэгслийн жолооч нарын зонхилон үйлдсэн зөрчлийг авч үзвэл:

-587,813 буюу 21.8 хувийг "Замын хөдөлгөөний дүрэмд заасныг зөрчин тээврийн хэрэгсэл байрлан явах журам зөрчсөн" зөрчил,

-531,170 буюу 19.7 хувийг "Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргаас харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн",

-388,746 буюу 14.4 хувийг "Жолооч замын хөдөлгөөний дүрэмд заасан хөдөлгөөнийг

эхлэх, эсхүл хөдөлгөөний чиг өөрчлөх, эсхүл эгнээ байр эзлэх журам зөрчсөн”,

- 180,191 буюу 6.7 хувийг “Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар жолооч тээврийн хэрэгслийг явган хүний гарц дээр, замын тэмдгээр зөвшөөрөгдөөгүй явган хүний зам дээр зогсоож явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулсан” зөрчил,

- 178,947 буюу 6.6 хувийг “Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар тээврийн хэрэгслийн жолооч, эсхүл зорчигч хамгаалах бүс хэрэглээгүй” зөрчил,

- 146,696 буюу 5.4 хувийг Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил,

- 119,176 буюу 4.4 хувийг “Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар жолооч тээврийн хэрэгслийг зорчих хэсэг дээр түр, удаан зогсоох журам зөрчиж бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулсан” зөрчил тус тус эзэлж байгаа нь хамгийн их байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/708